

Эрvvл мэндийн сайд Д.Сарангэрэл Австрали Улсын Мельбурн хотын Роял Вумэнс эмнэлгийн эх барих эмэгтэйчvvдийн эмч Ким Жансен тэргvvтэй эмч нарыг хvлээн авч уулзлаа.

Уулзалтын эхэнд Эрvvл мэндийн сайд Д.Сарангэрэл Австрали Улсын Мельбурн хотын Роял Вумэнс эмнэлгийн эх барих, эмэгтэйчvvдийн эмч Ким Жансен-аар ахлуулсан 11-15 эмч, сувилагч, инженер бvхий эмчилгээний баг 2009 оноос хойш жил бvр Монгол Улсад ирж ажиллаж байгаад талархал илэрхийлээд энэхvv vйл ажиллагаа нь Монгол Улсын эрvvл мэндийн салбарын хогжилд ихээхэн хувь нэмэр оруулж байгааг онцоллоо.

